

NATIONAL STATISTICS OFFICE
OF MONGOLIA



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКСИЙГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Аз жаргалын индекс 2016
тогтвортой, сайхан байдлын индекс



$$\text{HPI} = \frac{\text{Smiley Face} \times \text{Heart} \times \text{Scales}}{\text{Lightbulb}}$$



Хянасан: А.Дэмбэрэл /СЭШАЗГ-ын дарга, доктор, профессор/

Боловсруулсан:

Ш.Ариунболд /СЭШАЗГ-ын ахлах статистикч/

Ц.Янжиндулам /СЭШАЗГ-ын ахлах шинжээч/

Б.Мягмархатан /СЭШАЗГ-ын ахлах шинжээч/

Э.Энхцацрал /ГХХ -ийн ахлах шинжээч/

АГУУЛГА

1. Аз жаргалын индексийг тооцох нь
2. Монгол Улсын аз жаргалын индекс, 2016
 - 2.1 Тогтвортой, сайн сайхан байдал
 - 2.2 Хүн амын дундаж наслалт
 - 2.3 Экологийн нөөцийн эрэлт
3. Дүгнэлт, зөвлөмж

1. АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХ НЬ



Аз жаргалын индекс нь дэлхий нийтийн тогтвортой сайн сайхан амьдралд юу чухал вэ гэдгийг хэмжиж буй үзүүлэлт юм. Энэ нь улс үндэстнүүдийн урт, аз жаргалтай, тогтвортой амьдралд хүрэх үйл явц ямар байгааг харуулна.

Дэлхий нийтийн хандлагаар амжилтын үлгэрлэл хэмээгддэг барууны баян чинээлэг орнууд Аз жаргалын индексээр тийм ч өндөрт эрэмбэлэгддэггүй. Харин Латин Америк болон Ази, Номхон Далайн бүсийн хэсэг орнууд экологийн нөөцийн эрэлт бага, дундаж наслалт харьцангуй өндөр бөгөөд сайн сайхан байдлын үзүүлэлтээрээ тэргүүлж байна.

Аз жаргалын индекс нь байгаль дэлхийн нөөцийг аль болох бага ашиглан сайн сайхан амьдралд хүрэх боломжтой гэдгийг илтгэж, улс үндэстнийг уг зорилгод чиглүүлэх луужин болно.

Аз жаргалын индексийг тооцох нь:

Уг индекс нь тухайн улсын иргэд урт, аз жаргалтай амьдралд хүрэхэд хүрээлэн буй орчны баялгийг хэр зэрэг үр ашигтай ашиглаж байгааг харуулах 4 үндсэн үзүүлэлтийн нэгтгэл юм.

Зураг 1. Аз жаргалын индексийг тооцох томьёо

$$\text{HPI} = \frac{\text{Smiley Face} \times \text{Heart} \times \text{Scales}}{\text{Lightbulb}}$$



Сайн сайхан байдал: Тухайн улсын оршин суугчид амьдралдаа хэр зэрэг сэтгэл хангалуун байгааг 0-10 хоорондох тоон хэмжигдэхүүнээр үнэлсэн бөгөөд Дэлхийн олон нийтийн асуулга (Gallup World Poll)-ын судалгааны мэдээллийн сангаас сайн сайхан байдлын тоон мэдээллийг авч ашигласан.



Дундаж наслалт: НҮБ-ын улс орон тус бүрээр цуглуулсан хүн амын дундаж наслалтын тоон мэдээллийг ашигласан.



Тэгш бус байдал: Тухайн улсын иргэдийн удаан, аз жаргалтай амьдралын харилцан адилгүй байдал буюу хүмүүс хоорондын тэгш бус байдлыг улс бүрийн хүн амын дундаж наслалт болон сайн сайхан байдлын тоон мэдээллийн тархалт дээр үндэслэн гаргав.



Экологийн нөөцийн эрэлт: Тухайн улс орны иргэн бүрийн хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа дундаж нөлөөллийн тоон мэдээллийг Дэлхийн экологийн нөөцийн сангаас (Global Footprint Network) авч ашигласан.

Аз жаргалын индекс яагаад хэрэгтэй вэ?

Өнөөдөр мэдээллийн хэрэгслээр дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал, тэгш бус байдал нэмэгдэж байгаа тухай, уур амьсгалын томоохон өөрчлөлтүүд зэрэг хямралын тухай мэдээллүүд голлон цацагдаж байна. Сүүлийн үеийн судалгаагаар Америк болон Европт амьдарч байгаа хүн амын дийлэнхи нь цаашид амьдрал огт сайжрахгүй гэж үзсэн байна.

Эдгээр харилцан хамааралтай хямралуудын нэг шалтгаан нь Засгийн газрууд эдийн засгийн өсөлтийг гол зорилгоо болгон бусад зорилтыг орхигдуулсан явдал болно. Ард иргэд ч хүчирхэг эдийн засгийг байгуулах амлалт өгсөн улс төрийн намуудыг сонгож, бодлого боловсруулагчид бусад зорилтоос илүүтэйгээр эдийн засгийн өсөлтийн стандарт хэмжигдэхүүн болох ДНБ-ийг нэмэгдүүлэх бодлогыг нэн тэргүүнд тавьдаг. Энэ нь зөвхөн богино хугацааны үр дүнд чиглэгдэх бөгөөд нийгмийн нөхцөл байдлын доройтол, тулгарч байгаа уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг орхигдуулдаг. Бодит байдалд ДНБ-ий өсөлт нь дангаараа улс орны хөгжил, ард иргэдийн сайн сайхан амьдралыг илтгэж чадахгүй. Түүнчлэн тухайн улсын хүн амын доторхи тэгш бус байдлын зэргийг илэрхийлэхгүй. Мөн ДНБ нь нийгмийн харилцаа, эрүүл мэнд, хэрхэн чөлөөт цагаа өнгөрүүлдэг зэрэг хүмүүсийн чухалчилж авч үздэг үнэт зүйлсийг тусгадаггүй. Хамгийн гол нь үргэлж өсөн нэмэгдэж байдаг эдийн засгийн өсөлт нь байгаль дэлхийн хязгаарлагдмал нөөц баялагт нийцтэй биш юм.

Амжилтын тухай өөр төсөөлөл


Аз жаргалын индекс (АЖИ) нь хүмүүс хэрхэн амьдарч байгааг илүү тодорхой харуулна. Хүмүүс хэр урт насалж байгаа, өөрсдийн амьдралаас хэрхэн туршлагажиж байгаа зэргийг хэмжихээс гадна тэгш бус байдлыг дунджаар нь биш, түүний тархалтыг ашиглаж тооцдог.

Улс орнуудын тодорхой зорилтод хүрэхэд ашигласан байгалийн нөөцийг хэмжсэнээр АЖИ нь аль улс орны сайн сайхан байдал тогтвортой хадгалагдаж байгааг харуулна. Жишээ нь, Коста Рика бүх нийтийн тогтвортой сайн сайхан байдалд хүрэх замдаа амжилттай яваа бөгөөд бусад улс орнууд ч бүх нийтийн тогтвортой сайн сайхан байдлын төлөө урагшилж байна.

Аз жаргалын индекс 2016

Аз жаргалын индекс (АЖИ) нь дэлхийн улс орнууд өөрийн ард түмэндээ урт удаан, аз жаргалтай амьдрах боломжийг хэр зэрэг бүрдүүлж байгааг илтгэдэг. Зураг 2-т АЖИ-ийн өндөр үнэлгээнд хүрэхийн тулд байгаль орчны хязгаарлагдмал нөөцийн хүрээнд хүмүүс хэрхэн сайн сайхан амьдарч байгаагаар тодорхойлж байгаа бөгөөд уг жагсаалтыг Латин Америк болон Ази, Номхон Далайн бүсийн орнууд тэргүүлж, харин амжилтын бэлэг тэмдэг болсон барууны чинээлэг орнууд ард хоцорч байна.

Зураг 2. Дэлхийн улс орнуудын аз жаргалын индексийн үнэлгээгээр




Эх үүсвэр: www.happyplanetindex.org

АЖИ-г 2 хэмжигдэхүүний тусламжтайгаар илэрхийлснийг Зураг 3-т үзүүлэв. Улс орны сайн сайхан байдал, дундаж наслалт, орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг нэгтгэн Сайн сайхан амьдралын он жилүүд хэмээх нэг хэмжигдэхүүн болгосон бөгөөд экологийн нөөцийн эрэлтийг 2 дах хэмжигдэхүүн болгон сонгосон. Энд тухайн улс орны үзүүлэлт графикийн зүүн дээд булан дах ногоон хэсэгт ойртох тусам АЖИ нь нэмэгдэнэ. Ногоон хэсэг нь экологийн тогтвортой байдал болон амьдралын сайн сайхан байдал, дундаж наслалтын өндөр түвшин давхцаж байгааг илэрхийлнэ.

Барууны чинээлэг улс орнууд нь дундаж наслалт болон амьдралын сайн сайхан байдлын хэмжүүрт өндөр оноотой байгаа боловч тэдний өндөр эдийн

засгийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчны ихээхэн зардал гарч байгаагаас шалтгаалан АЖИ нь тийм ч өндөр бус байна.

Зураг 3. Аз жаргалтай амьдралын он жилүүд болон экологийн нөөцийн эрэлт



Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Тухайлбал, АНУ аз жаргалтай амьдралын он жилүүдийн үр дүнгээр өндөр оноо авч байгаа боловч, дэлхий дээрх хамгийн өндөр экологийн нөөцийн эрэлттэй орнуудын нэг тул АЖИ нь бага байна. Харин Коста Рика зэрэг экологийн нөөцийн эрэлт багатай олон улс орон аз жаргалтай амьдралын жилүүд өндөр, экологийн нөөцийн эрэлт бага байна. Өөрөөр хэлбэл, Коста Рика улс ард түмнийхээ сайн сайхан байдлыг хангахын зэрэгцээ харьцангуй бага хэмжээний экологийн нөөц ашиглаж байгаа нь АЖИ-ийг өндөр үнэлгээтэй болгож байна.

Зураг 3-ын ногоон хэсэгт ойрхон байгаа Коста Рика зэрэг улс орнууд экологийн нөөцийн бага эрэлттэйгээр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах замаар сайн сайхан байдал харьцангуй өндөр, дундаж наслалт их байх нөхцөл рүү амжилттай урагшилж байна.

Шигтгээ: Тэргүүлэгч Коста Рика #1

Энэ жил Коста Рика улс АЖИ-ийн үр дүнгээр 3 дахь удаагаа тэргүүлж байна. Коста Рикачууд аз жаргалтай сайн сайхан байдлаар АНУ, Их Британи зэрэг өндөр хөгжилтэй олон орноос, дундаж наслалтаар АНУ-аас өндөр байна. Тус орны нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлтийн хэмжээ нь АНУ-ынхаас 3 дахин бага байна.

Коста Рика нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаагаар дэлхийд тэргүүлж байна. Эрчим хүчний 99 хувь нь сэргээгдэх нөөцөөс бүрдэж байгаа бөгөөд Засгийн газар нь бусад хөгжингүй чинээлэг орнуудаас урьтаж нүүрстөрөгчийн хэрэглээг 2021 он гэхэд халсан орон болох шийдвэрийг гаргасан.

Тус улс 1949 оны цэргийн хөдөлгөөнөөс хойш батлан хамгаалахын төсвийг боловсрол, эрүүл мэнд, тэтгэврийн санхүүжилтэд дахин хуваарилсан байна. Коста Рикачууд аз жаргалтай байгаа гол хүчин зүйлийн нэг нь найз нөхөд, гэр бүл, хөршүүдээрээ нийгмийн үйл ажиллагаанд нийлэн нэгддэг хатуу дэг жаяг, соёлтой нь холбоотой юм.

Гэвч Коста Рикад маш олон шийдвэрлэх асуудал байсаар байна. Хоцрогдсон татварын систем болон орлогын тэгш бус байдал өндөр. Коста Рикагийн байгаль орчны тогтвортой байдлын төлөө өгсөн амлалт нь сайшаалтай боловч бүрэн тогтвортой байдалд хүрээгүй л байна.

Хүснэгт 1. Аз жаргалын индекс, 2016

Улс орон	NPI	Дундаж наслалт	Сайн сайхан байдлын индекс	Экологийн нөөцийн эрэлт	Орлогын тэгш бус байдлын индекс
1 Коста Рика	44.7	7.3	79.1	15%	2.8
2 Мексик	40.7	7.3	76.4	19%	2.9
3 Колумб	40.7	6.4	73.7	24%	1.9
4 Вануату	40.6	6.5	71.3	22%	1.9
5 Вьетнам	40.3	5.5	75.5	19%	1.7
6 Панам	39.5	6.9	77.2	19%	2.8
7 Никарагуа	38.7	5.4	74.3	25%	1.4
8 Бангладеш	38.4	4.7	70.8	27%	0.7
9 Тайланд	37.3	6.3	74.1	15%	2.7
10 Эквадор	37.0	6.0	75.4	22%	2.2
11 Ямайка	36.9	5.6	75.3	21%	1.9
12 Норвеги	36.8	7.7	81.3	7%	5.0
13 Албани	36.8	5.5	77.3	17%	2.2
14 Уругвай	36.1	6.4	76.9	18%	2.9
15 Испани	36.0	6.3	82.2	10%	3.7
16 Индонез	35.7	5.4	68.5	21%	1.6
17 Эл Сальвадор	35.6	5.9	72.5	22%	2.1
18 Нидерланд	35.3	7.5	81.2	4%	5.3
19 Аргентин	35.2	6.5	75.9	16%	3.1
20 Филиппин	35.0	5.0	67.9	26%	1.1
21 Перу	34.6	5.8	74.1	21%	2.3
22 Палестин	34.5	4.6	72.6	24%	1.2
23 Бразил	34.3	6.9	73.9	22%	3.1
24 Швейцар	34.3	7.8	82.6	6%	5.8
25 Тажикистан	34.2	4.5	69.0	26%	0.9
26 Гватемал	34.2	5.9	71.4	27%	1.9
27 Белиз	33.8	6.1	69.8	18%	2.5
28 Шри Ланка	33.8	4.2	74.6	17%	1.3
29 Венесуэл	33.6	7.1	73.9	19%	3.6
30 Алжир	33.3	5.6	74.3	24%	2.1
31 Кыргызстан	33.1	5.2	69.7	18%	1.9
32 Дани	32.7	7.5	79.8	7%	5.5
33 Марокко	32.7	5.0	73.4	25%	1.7
34 Их Британи	31.9	6.9	80.4	9%	4.9
35 Чили	31.7	6.6	81.1	14%	4.4
36 Пакистан	31.5	5.1	65.7	40%	0.8
37 Финлянд	31.3	7.4	80.4	6%	5.9
38 Шинэ Зеланд	31.3	7.2	81.4	8%	5.6
39 Исланд	31.1	7.6	82.2	5%	6.4
40 Гүрж	31.1	4.3	74.6	20%	1.6
41 Кипр	30.7	6.2	79.8	12%	4.2
42 Непал	30.5	4.2	68.8	27%	1.0
43 Австри	30.5	7.4	81.0	7%	6.1
44 Франц	30.4	6.6	81.8	9%	5.1
45 Доминикан	30.3	4.8	73.1	30%	1.5
46 Малайз	30.3	5.9	74.4	10%	3.7
47 Хорват	30.2	6.0	77.0	12%	3.9
48 Ирланд	30.0	7.0	80.5	8%	5.6
49 ХБНГУ	29.8	6.7	80.6	8%	5.3
50 Энэтхэг	29.2	4.6	67.3	31%	1.2
51 Узбекистан	29.1	6.0	68.2	30%	2.3
52 Серб	29.0	5.2	74.5	19%	2.7
53 Мальта	29.0	6.0	80.2	13%	4.4
54 Израиль	28.8	7.1	81.9	8%	6.2
55 Румын	28.8	5.2	74.3	19%	2.7
56 Бутан	28.6	5.6	68.7	27%	2.3
57 Гайти	28.6	4.4	62.1	37%	0.6
58 Япон	28.3	6.0	83.2	9%	5.0
59 Словак	28.2	5.9	75.9	13%	4.1
60 Итали	28.1	5.8	82.7	12%	4.6
61 Швед	28.0	7.6	81.8	6%	7.3
62 Польш	27.5	5.9	76.9	11%	4.4
63 Маврикий	27.4	5.5	74.0	17%	3.5
64 Чех	27.3	6.3	78.2	9%	5.2
65 Гондурас	27.2	4.6	72.8	31%	1.7
66 Этиоп	26.7	4.6	62.8	36%	1.0
67 Ирак	26.5	4.7	69.0	27%	1.9
68 Турк	26.4	5.3	74.7	19%	3.3
69 Унгар	26.4	4.7	74.9	15%	2.9
70 Украин	26.4	5.0	70.3	17%	2.8
71 Тунис	26.2	4.5	74.6	22%	2.3
72 БНХАУ	25.7	5.1	75.4	17%	3.4
73 Армен	25.7	4.3	74.4	22%	2.2
74 Камбож	25.6	3.9	67.5	28%	1.2
75 Суринам	25.4	6.3	70.8	19%	4.3
76 Босни Герцоговин	25.3	4.8	76.2	19%	3.1
77 Замби	25.2	5.0	58.4	41%	1.0
78 Монтенегро	25.1	5.2	75.8	16%	3.8
79 Португал	24.8	5.0	80.3	16%	3.9
80 БНСУ	24.8	6.0	81.3	11%	5.7
81 Мьянмар	24.7	4.4	65.5	32%	1.4
82 Словени	24.6	6.1	80.0	10%	5.8
83 Кени	24.2	4.5	60.3	38%	1.0

Улс орон	NPI	Дундаж наслалт	Сайн сайхан байдлын индекс	Экологийн нөөцийн эрэлт	Орлогын тэгш бус байдлын индекс
84 Иран	24.0	4.6	74.8	23%	2.8
85 Канад	23.9	7.4	81.7	9%	8.2
86 Египет	23.8	4.2	70.7	23%	2.2
87 Бельги	23.7	6.9	80.4	9%	7.4
88 Мозамбик	23.7	5.0	54.3	43%	0.9
89 Грек	23.6	5.1	80.5	16%	4.4
90 Македон	23.4	4.6	75.1	18%	3.3
91 Парагвай	23.3	5.8	72.6	22%	4.2
92 Боливи	23.3	6.0	67.5	35%	3.0
93 Комор	23.1	4.0	62.6	36%	1.0
94 Йемен	22.8	4.1	63.3	39%	1.0
95 Нигери	22.2	5.5	52.1	44%	1.2
96 Либери	22.2	4.4	60.2	38%	1.2
97 Танзани	22.1	4.0	63.5	33%	1.3
98 Малави	22.1	4.3	60.1	45%	0.8
99 Зимбабве	22.1	5.0	53.7	37%	1.4
100 Ливан	21.9	4.6	78.8	19%	3.8
101 Сенегал	21.9	3.7	65.4	33%	1.2
102 Беларусь	21.7	5.7	70.9	13%	5.1
103 Намиби	21.6	4.7	64.0	26%	2.5
104 Гана	21.4	5.1	61.0	38%	2.0
105 Австрали	21.2	7.2	82.1	8%	9.3
106 Оман	21.1	6.9	76.3	13%	7.5
107 Литви	21.0	5.8	72.8	11%	5.8
108 АНУ	20.7	7.0	78.8	13%	8.2
109 Болгар	20.4	4.2	73.9	19%	3.3
110 Афганистан	20.2	3.8	59.7	43%	0.8
111 Руанда	19.6	3.3	63.1	37%	0.9
112 Уганда	19.4	4.3	57.1	41%	1.2
113 Сири	19.1	3.2	70.4	30%	1.5
114 Казахстан	19.1	5.8	68.6	18%	5.6
115 Конго БН	18.8	3.9	61.0	40%	1.3
116 ОХУ	18.7	5.6	69.5	16%	5.7
117 Мавритани	18.0	4.7	62.6	37%	2.5
118 Эстон	17.9	5.4	76.2	12%	6.9
119 Буркина Фасо	17.9	4.0	58.0	43%	1.2
120 Габон	17.5	4.0	63.3	36%	2.0
121 Латви	17.1	5.1	73.6	14%	6.3
122 Нигер	16.8	3.8	60.0	40%	1.6
123 Гонконг	16.8	5.5	83.6	10%	8.8
124 Камерун	16.7	4.2	54.6	47%	1.2
125 Лесото	16.7	4.9	48.9	42%	1.7
126 Бостван	16.6	4.8	64.2	28%	3.8
127 Джибути	16.4	4.4	61.3	42%	2.2
128 ӨАБНУ	15.9	5.1	56.3	33%	3.3
129 Гвиней	15.9	3.7	57.7	42%	1.4
130 Тринадад ба Тобаго	15.7	6.4	70.1	21%	7.9
131 Бурунди	15.6	3.4	55.8	48%	0.8
132 Свазиленд	15.5	4.9	48.9	41%	2.0
133 Сьерра Леон	15.3	4.5	49.8	50%	1.2
134 Туркменстан	14.6	5.5	65.3	31%	5.5
135 Кот д'Иваур	14.4	3.8	50.8	45%	1.3
136 Монгол	14.3	4.9	68.6	22%	6.1
137 Бенин	13.4	3.2	59.2	44%	1.4
138 Того	13.2	2.9	58.6	43%	1.1
139 Люксембург	13.2	7.0	81.1	7%	15.8
140 Чад	12.8	4.0	50.8	51%	1.5



Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Зураг 3. Аз жаргалын индексийн өнгөний тайлбар

АЖИ-ийн өнгөний илэрхийлэл болон агуулга

Кодны агуулга

Наслалт, жилээр

Өндөр	75-аас их бол
Дундаж	65-аас 75-ын хооронд
Бага	65-аас бага бол

Дундаж аз жаргалтай байдал (0-10)

Сайн	6-аас их бол
Дунд	5-аас 6-гийн хооронд
Тааруу	5-аас бага бол

Зардлын тэнцвэртэй бус байдал

Өндөр	15%-аас их бол
Дундаж	15% -аас их 30%-аас бага
Бага	30%-аас их

Экологийн нөөцийн эрэлт (global hectares per capita)

Сайн	1.73-аас бага бол (дэлхийн биологийн чадавхитай тэнцүү)
Дунд	1.73-аас их 3.46-гаас бага бол
Тааруу	3.46-аас их бол

АЖИ-ийн өнгөний код


	44.6-гаас их
	40.7-44.6
	36.7-40.6
	32.7-36.6
	28.7-32.6
	24.8-28.6
	20.8- 24.7
	16.8-20.7
	16.8-аас бага бол

Эх үүсвэр: www.happyplanetindex.org

2. МОНГОЛ УЛСЫН АЗ ЖАРГАЛЫН ИНДЕКС

Аз жаргалын 2016 оны тайланд нийт 140 орны аз жаргалын индексийг тооцоолж, эрэмбэлсэн бөгөөд Монгол Улс 14.3 гэсэн үнэлгээгээр 136 дугаар байранд эрэмбэлэгджээ.

Зураг 5. Дэлхийн аз жаргалын индекс, 2016



Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Монгол Улс АЖИ-ийн үр дүнгээр аз жаргалгүй улс орнуудын нэг болж байгаа бөгөөд дэлхийн дунджаас 1.8 дахин, нэгдүгээрт эрэмбэлэгдэж байгаа Коста Рика улсаас 3.1 дахин бага үнэлгээтэй байна.

Хүснэгт 2. Аз жаргалын индексийн эрэмбэ

Эрэмбэ	Аз жаргалын индекс	
1	Коста Рика	44.7
2	Мексик	40.7
3	Колумб	40.7
Дэлхийн дундаж		26.4
136	Монгол	14.3
138	Того	13.2
139	Люксембург	13.2
140	Чад	12.8

Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Монгол Улсын АЖИ нь бага үр дүнтэй гарсан нь түүний бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээнээс шууд хамаарч байна.

Хүн амын дундаж наслалтын хувьд жилээс жилд нэмэгдэж байгаа боловч хангалттай түвшинд хүрээгүй байна. Сайн сайхан байдал буюу амьдралын сэтгэл ханамжийн түвшин дунджаас доогуур 4.9 гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд энэ нь аз жаргалын индексийн бага үр дүнтэй гарахад ихээхэн нөлөөлсөн.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт (6.1 га) нь боломжит нөөцийн хэмжээ (15.7 га)-нээс бага байгаа боловч дэлхийн дундаж экологийн нөөцийн эрэлтээс 2.2 дахин их байгаа нь тухайн үзүүлэлтийн түвшинд нөлөөлсөн.

Хүснэгт 3. Монгол Улсын аз жаргалын индексийн задаргаа

Эрэмбэ	Улс	Хүн амын дундаж наслалт (жил)	Сайн сайхан байдал (0-10)	Экологийн эрэлт (га/нэг хүнд ногдох)	Аз жаргалын индекс
136	Монгол Сайн байх шалгуур	68.6	4.9	6.1	= 14.3
		>75	>6.0	<1.73	

Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Монгол Улсын аз жаргалын индекс 2016 онд 14.3 гарсан. Дээрх үзүүлэлтийн дагуу Монгол Улсын ард иргэдийг сайн сайхан амьдралд хөтлөх, ирээдүй хойч үедээ сайн сайхан амьдралаа өвлүүлж үлдээх, шавхагдаж байгаа байгалийн нөөц баялгаа зохистойгоор ашиглах, "тогтвортой сайн сайхан байдал" -ын төлөө хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн амьдралын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарах, байгаль дэлхийн хязгаарлагдмал нөөцөд тулгуурлан хэрэглээний зохистой бүтцийг бий болгоход тодорхой зорилт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.1 Тогтвортой сайн сайхан байдал

“Сайн сайхан байдал”-ын тухай

“Галлап Уорлд”-ийн (Gallup World) “Амьдралын үе шат” гэж нэрлэдэг судалгааны асуултыг ашиглан 2012 оны 02 дугаар сарын байдлаар дэлхийн улс орнуудын хувьд тооцсон сайн сайхан байдлын санал асуулгад дэлхийн 150 гаруй орны 15, түүнээс дээш насны 1000 хүн хамрагдсан байна. Судалгааны асуулт нь:

Та 0-оос 10 хүртэл дугаарласан амьдралын үе шатыг төсөөлөөд, хамгийн дээд шат таны хувьд боломжит хамгийн сайн сайхан амьдрал, харин хамгийн доод шат нь боломжит хамгийн хүнд хэцүү амьдрал гэж төсөөлөө. Хэрэв та өөрийн амьдралыг сайнаар төсөөлж байгаа бол дээд шатанд, муугаар төсөөлж байгаа бол доод шатанд байна гэж таамаглавал та яг одоо аль шатанд явж байна вэ? Та аль шатанд хамгийн ойрхон байна гэж мэдэрч байна вэ?

Монгол Улсын хувьд сайн сайхан байдал 4.9 гэсэн үнэлгээтэй гарчээ. Энэ нь дэлхийн дунджаас 0.5 нэгжээр доогуур байна. Мөн энэ үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн 140 улсаас 90 дүгээр байранд оржээ. Харин Швейцари улсын сайн сайхан байдал хамгийн өндөр буюу 7.8 байгаа бол Того улсад хамгийн бага буюу 2.9 байна.

Хүснэгт 4. Улс орнуудын сайн сайхан байдал

Эрэмбэ	Туршлагажсан сайн сайхан байдал	
1	Швейцари	7.8
2	Норвеги	7.7
3	Исланд	7.6
Дэлхийн дундаж		5.4
90	Монгол	4.9
138	Сири	3.2
139	Бенин	3.2
140	Того	2.9


Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Сайн	6-аас их бол
Дунд	5-аас 6-гийн хооронд
Тааруу	5-аас бага бол

Азийн өндөр хөгжилтэй улс: БНСУ, БНХАУ, Япон

Монгол Улсын сайн сайхан байдлын үнэлэмж 4.9 байгаа нь Зүүн Өмнөд Азийн өндөр хөгжилтэй улс орнууд болох Япон болон БНСУ-ынхаас 1.1 нэгжээр доогуур байна. Харин БНХАУ-ынхтай ойролцоо түвшинд байна.


Зураг 6. Азийн өндөр хөгжилтэй улс орнууд болон Монгол Улсын сайн сайхан байдал, 2012



Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Монгол Улсын сайн сайхан байдал нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн бага улс орнуудынхаас дээгүүр боловч Мозамбик улсынхаас доогуур байна. Харин эдгээр улс орнуудын сайн сайхан байдал дэлхийн дунджаас доогуур байна.


Зураг 7. Нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн бага улс орнууд болон Монгол Улсын сайн сайхан байдал, 2012



Эх үүсвэр: www.happyplanetindex.org

Монгол Улсын сайн сайхан байдал нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн өндөр улс орнуудынхаас харьцангуй доогуур байна. Харин эдгээр улсуудын хувьд сайн сайхан байдал нь дэлхийн дунджаас дээгүүр байна.

Зураг 8. Нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн өндөртэй улс орнууд болон Монгол Улсын сайн сайхан байдал, 2012




Эх үүсвэр: www.happyplanetindex.org

2.2 Хүн амын дундаж наслалт

Хүн амын дундаж наслалт гэж шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг (жил) ойлгоно. Дундаж наслалтын тооцоонд насны бүлгээрх нас баралтын тоо болон хүн амын тоо, төрөх үеийн хүйсийн харьцаа, нялхсын эндэгдлийн түвшинг ашигладаг бөгөөд шинээр төрсөн хүүхдийн төрөх үед байсан нас баралтын түвшин уг хүүхдийн амьдралынх нь хугацаанд хэвээр хадгалагдаж байх таамаглалыг дэвшүүлж тооцооллыг хийж байна.

Монгол Улсын хувьд хүн амын дундаж наслалт нь 2009 оноос хойш жил бүр нэмэгдсэн. Хүн амын дундаж наслалт 2009 онд 68.0 жил байсан бол 2015 онд 69.9 жил болж өссөн нь 6 жилийн хугацаанд дундаж наслалт 1.9 жилээр нэмэгдсэнийг илтгэж байна.

Зураг 9. Монгол Улсын хүн амын дундаж наслалт, жилээр, 2009-2015



Эх үүсвэр: www.1212.mn

Монгол Улсын хүн амын дундаж наслалт дэлхийн 140 улсаас 95-т оржээ. Мөн дэлхийн дунджаас 2.3 жилээр доогуур байна.

Дэлхийд хүн амын дундаж наслалтаар Гонконг, Япон, Итали, Швейцар зэрэг улсууд тэргүүлж, Сьерра Леон, Лесото, Свазиланд зэрэг улсууд сүүлдэж байна. Монгол Улсын хүн амын дундаж наслалт нь тэргүүлж байгаа улс орнуудынхаас 14.0-15.0 жилээр доогуур байгаа бол сүүлдэж байгаа улс орнуудынхаас 18.8-19.7 жилээр өндөр байна. Дэлхийн хүн амын дундаж наслалтыг тэргүүлж байгаа улс орнуудыхтай харьцуулбал 11.8-12.7 жилээр бага, сүүлдэж байгаа 3 улсынхаас 22.1-22.0 жилээр өндөр байна.

Хүснэгт 5: Хүн амын дундаж наслалт хамгийн их болон бага улс, 2012

Эрэмбэ	Улс	Дундаж наслалт, жилээр
1	Гонконг	83.6
2	Япон	83.2
3	Итали	82.7
4	Швейцар	82.6
5	Исланд	82.2
6	Испани	82.2
7	Австрали	82.1
Азийн дундаж		73.2
Дэлхийн дундаж		70.9
95	Монгол	68.6
138	Сьерра Леон	49.8
139	Лесото	48.9
140	Свазиланд	48.9

Эх үүсвэр: www.happyplanetindex.org


Өндөр	75-аас их бол
Дундаж	65-аас 75-ын хооронд
Бага	65-аас бага бол

Азийн өндөр хөгжилтэй улс: БНСУ, БНХАУ, Япон

Монгол Улс хүн амын дундаж наслалтаараа Азийн өндөр хөгжилтэй улс орнууд болон дэлхийн дунджаас доогуур байна.

Монгол Улсын хүн амын дундаж наслалтыг Азийн өндөр хөгжилтэй улс орнуудынхтай 2015 оны байдлаар харьцуулан үзэхэд Японых 14.6, БНСУ-ынх 12.7, БНХАУ-ынх 6.8 жилээр их байна. Харин Монгол Улс нь Азийн дунджаас 4.6 жилээр бага байна.


Зураг 10. Азийн өндөр хөгжилтэй улс орон болон Монгол Улсын хүн амын дундаж наслалт, жилээр, 2012



Эх үүсвэр: www.happyplanedindex.org

Монгол Улсын хүн амын дундаж наслалтыг нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн бага улс орнуудынхтай харьцуулахад эдгээр улсынхаас өндөр байна. Эдгээр улс орнуудын дундаж наслалт дэлхийн дунджаас 8.1-16.6 жилээр, Монгол Улсынхаас 5.8-14.3 жилээр доогуур байна.

Зураг 11. Нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн бага улс орнууд болон Монгол Улсын хүн амын дундаж наслалт, жилээр, 2012



Эх үүсвэр: www.happyplannedindex.org

Харин Монгол Улсын хүн амын дундаж наслалтыг нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн өндөр улс орнууд болон дэлхийн дундажтай харьцуулахад эдгээр улсаас болон дэлхийн дунджаас доогуур байна.

Зураг 12. Нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн өндөр улс орнууд болон Монгол Улсын хүн амын дундаж наслалт, жилээр, 2012




Эх үүсвэр: www.happyplannedindex.org

2.3 Экологийн нөөцийн эрэлт

Сүүлийн 50 жилийн хувьд экологийн нөөцийн эрэлтийг авч үзэхэд манай улсын хувьд тогтвортой байгаа нь харагдаж байгаа боловч байгалийн нөөц (чадамж)-ийн хувьд жил ирэх тутам багасч байна. Энэ нь цаашид огтлолцож эрэлт нь нөөцийн чадавхиас давж болзошгүйг харуулж байна.

Зураг 13. Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон биочадавх, га-аар, 1961-2012




Эх үүсвэр: *Global Footprint Network*

Экологийн нөөц нь:

- Тариалангийн
- Бэлчээрийн
- Ой хээрийн
- Усны нөөцийн
- Барилга, байгууламжийн гэсэн 5 хэсэг талбайгаас бүрддэг байна.

Нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөцийн байдлыг Монгол Улсын хувьд бүтцээр нь аваад үзэхэд тариалангийн талбайн эрэлт нь нөөцөөсөө давж гарсан байгаа боловч бусад талбайн нөөц нь илүү байгаа тул нийт экологийн нөөц эрэлтээсээ 2.3 дахин их байна. Манай улсын хувьд экологийн нөөцийн ихэнх хувийг бэлчээр, ой хээрийн нөөц эзлэдэг бол эрэлтийн хувьд бэлчээрийн талбай ихэнх хувийг эзлэж байна.

Зураг 14. Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөц, ашиглалтын төрлөөр, га-аар, 2012




Эх үүсвэр: *Global Footprint Network*

Азийн өндөр хөгжилтэй улс: БНСУ, БНХАУ, Япон

Манай улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөцийг Азийн өндөр хөгжилтэй улс орнууд болон дэлхийн дундажтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Япон, БНХАУ, БНСУ орнууд өөрсдийн нөөцөөс илүү их хэрэглээтэй байгаа нь харагдаж байна. Энэ нь хүн амын тоо болон тухайн улсын хөгжлийн түвшинтэй уялдаа холбоотой.


Зураг 15. Азийн өндөр хөгжилтэй улсууд болон Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөц, га-аар, 2012



Эх үүсвэр: *Global Footprint Network*

Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөцийг дэлхийн хамгийн өндөр орлоготой буюу нэг хүнд ногдох ДНБ нь хамгийн өндөр 8 улс орнуудынхтай харьцуулахад Австрали, Канад, Монгол, Швед болон Норвеги улс орнуудын экологийн нөөц нь эрэлтээсээ өндөр бол Люксембург, АНУ, Швейцар, Дани улсын орнуудын экологийн нөөц нь эрэлтээсээ бага байна.


Зураг 16. ДНБ нь хамгийн өндөр улс орнууд болон Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөц, га-аар, 2012



Эх үүсвэр: *Global Footprint Network*

Монгол Улсын хүн амын тоотой ойролцоо 9 улс орныг харьцуулахад Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөц өндөр байгаа бөгөөд Уругвай, Намиби улс орнуудын экологийн нөөц нь эрэлтээсээ өндөр байна. Харин бусад улс орнуудын экологийн нөөц нь эрэлтээсээ бага байна.

Зураг 17. Монгол Улсын хүн амын тоотой ойролцоо орнуудын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт болон нөөц, га-аар, 2012



Эх үүсвэр: *Global Footprint Network*

Нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлтийн хэмжээгээр эхний 3-т орж буй улс орнуудыг харахад бүгд өндөр орлоготой байгаа бол сүүлийн 3-т орсон улс орнууд бүгд бага орлоготой улс байна. Монгол Улсын нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт Ази тивийн болон дэлхийн дундаж эрэлтээс их байгаа боловч экологийн нөөцөөс бага байна. Харин нэг хүнд ногдох экологийн нөөцийн эхний байранд байгаа улс орнууд Латин-Америк тивийн улс орон байна.

Хүснэгт 6. Зарим улс орны экологийн нөөцийн эрэлт болон нөөц, нэг хүнд ногдох хэмжээгээр

Эрэм бэ	Нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт, га-аар		Нэг хүнд ногдох экологийн нөөц, га-аар	
1	Люксембург	15.8	Францын Гвиней	111.4
2	Аруба	11.9	Суринам	89.3
3	Катар	10.8	Гайана	66.6
19-8	Монгол	6.1	Монгол	15.6
Дэлхийн дундаж		2.8	Дэлхийн дундаж	1.7
185	Гайти	0.6	Реюнион	0.2
186	Тимор Лесте	0.5	Бермуд	0.1
187	Эритрей	0.4	Сингапур	0.1

Эх үүсвэр: *Global Footprint Network*

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дэлхийн түвшинд аз жаргалын индекс 2016 оны тайланд дунджаар 26.4 байгаа нь улс орнуудын хүн амын сайн сайхан байдал, амьдралаас авах сэтгэл ханамжийн түвшингээс доогуур байгааг илтгэж байна.

Аз жаргалын индекс Коста Рикад хамгийн өндөр буюу 44.7, Чад улсад хамгийн бага буюу 12.8 байна. Харин Монгол Улсын АЖИ 14.3 юм.

Монгол Улсын аз жаргалын индекс 14.3 гарахад хүн амын сайн сайхан байдал 4.9, нэг хүнд ногдох экологийн нөөцийн эрэлт 6.1 га байгаа нь сөргөөр нөлөөлжээ.

Монгол Улс аз жаргалын индексээр дэлхийн 140 орноос 136, үзүүлэлт тус бүрээр авч үзэхэд тогтвортой сайн сайхан байдлаар 90, хүн амын дундаж наслалтаар 95, экологийн нөөцийн эрэлтээр 14 дүгээр байранд тус тус эрэмбэлэгджээ.

Цаашид Монгол Улс хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, орлогын тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх, экологийн нөөцийг зөв зохистой ашиглах, түүнийг нөхөн сэргээх арга хэмжээг авах шаардлагатай байна.